



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2018. 10-18 № 44

Асуулга тавих тухай

Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банкттай 2017-2020 онд санхүү, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, байгаль орчны хамгаалал, боловсрол, нийгмийн салбаруудад хамтран ажиллахаар тохиролцсон байдаг.

Дээрх салбаруудын хүрээнд Азийн хөгжлийн банкнаас манай улсад 468 сая ам.долларын санхүүжилтийн эх үүсвэрийг хуваарилсан бөгөөд 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Монгол Улсын Их хурлын чуулганаар хэлэлцэж “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр батлах тухай” хуулийг соёрхон баталсан билээ.

Хөтөлбөрийн зээлийн төлөвлөгөөнд 2017-2018 онд эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар ба хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор Улаанбаатар хот болон зарим аймгуудын хамгийн их ачаалалтай байгаа сургууль, цэцэрлэгийн барилгыг шинээр барих, засварлах, өргөжүүлэх, бүс нутгийн замыг хөгжүүлэх /үүнд: Улаанбаатар-Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын засварын ажлуудыг хийх, өгсүүр хэсгүүдэд нэмэлт эгнээ барих, мөн Улаанбаатар-Дархан чиглэлийн замаас Мандал сум чиглэлийн зам болон зарим дэд замуудын засварын ажлууд/, Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах, тогтвортой аялал жуулчлалыг дэмжих, сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх, төсвийн санхүүгийн удирдлагын ил тод үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зэрэг олон чухал төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж хамтран ажиллахаар тохирсон. Гэвч хууль батлагдсан өдрөөс хойш өнөөдрийг хүртэлх хагас жил гаруйн хугацаанд тодорхой ажил хийгдэхгүй удааширч ирлээ.

Иймд миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд уг хэрэгжилт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дараах асуулгыг танд тавьж байна.

1. Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр батлагдсантай холбогдуулан Монгол Улсын засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ажлуудын талаар /яам тус бүрээр/
2. Харьяалах яам тус бүрт тухайн чиглэлээр ажиллах төслийн нэгж байгуулагдсан эсэх талаар,
3. Зээлийн гэрээний хавсралтад тусгагдсан төсөл хөтөлбөрийн жагсаалтад ямар нэгэн өөрчлөлт орсон эсэх талаар,
4. Төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэлүүдийг гаргасан эсэх талаар,

5. Төслүүд хэрэгжиж эхлэхгүй удааширч буй шалтгаан, хэзээ хэрхэн эхлүүлэх талаар тодорхой мэдээлэл бэлтгэж ирүүлнэ үү.

Асуулгын хариуг Монгол улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар сонсгохыг хүсье.

Хувийг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар

Хүндэтгэсэн ,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Б.ЖАВХЛАН